



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 121

Улаанбаатар хот

“Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх аудит,¹
үнэлгээний байгууллага, хуулийн компанийг бүртгэх тухай”
журам батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Хорооны 2009 оны 38 дугаар тогтоол, тус тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай” журмын 2.2.1, 2.2.2, 2.2.3 дахь заалтуудыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компанийг бүртгэх тухай” журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавих, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.




ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

**ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АУДИТ, ҮНЭЛГЭЭНИЙ
БАЙГУУЛЛАГА, ХУУЛИЙН КОМПАНИЙГ БҮРТГЭХ ТУХАЙ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл



1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хорооны /цаашид “Хороо” гэх/ 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай” журмын 2.2.1, 2.2.2, 2.2.3 дахь заалтад тусгагдсан үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд аудит, үнэлгээний болон хуульчийн дүгнэлт гаргах, үйлчилгээ үзүүлэх этгээдийг бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журамд дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

1.2.1. “үнэт цаас гаргагч” гэж олон нийтэд санал болгон хувьцаа, бонд, бусад үнэт цаас шинээр болон нэмж гаргах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасуулах хүсэлтээ Хороонд албан ёсоор ирүүлсэн компани, бусад этгээдийг;

1.2.2. “аудит, үнэлгээний байгууллага” гэж энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;

1.2.3. “хуулийн компани” гэж хууль, эрх зүйн мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийг;

1.2.4. “бүртгэгдсэн этгээд” гэж Хорооноос тавьсан шаардлагыг хангаж үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэхээр бүртгэгдсэн аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компанийг;

1.3. Бүртгэгдсэн этгээд Хорооноос зөвшөөрсөн хугацаанд үйлчилгээ үзүүлэх эрхтэй байна.

1.4. Хороонд бүртгэлгүй болон энэхүү журмын шаардлагыг хангаагүй нь тогтоогдсон этгээдийн гаргасан дүгнэлтийг Хороо хүлээн зөвшөөрөхгүй.

1.5. Бүртгэгдсэн этгээд энэхүү журмаар тавигдсан шаардлагыг биелүүлж ажиллах, гарсан өөрчлөлтийг тухай бүр Хороонд ирүүлэх үүрэгтэй.

**Хоёр. Бүртгэгдэх аудитын байгууллагад
тавигдах шаардлага**

2.1. Бүртгэгдэх аудитын байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1. аудитын үйл ажиллагааг 3-аас доошгүй жил эрхэлсэн байх;

2.1.2 Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт /цаашид “ММНБИ” гэх/-ээс зохион байгуулсан үнэт цаасны зах зээлийн талаарх төрөлжсөн сургалтад бүрэн хамрагдаж үнэмлэх авсан 2 ба түүнээс дээш орон тооны аудитортой байх;

2.1.3 аудиторууд нь мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдал гаргаж байгаагүй, энэ талаар ММНБИ-ээс тодорхойлолт гаргуулсан байх;

2.1.4 Хороо болон холбогдох эрх бүхий байгууллагаас хамтран зохион байгуулсан чанарын хяналтын шалгалтад хангалттай үнэлгээ авсан байх;

2.1.5. хууль тогтоомжид заасан бусад.

**Гурав. Бүртгэгдэх үнэлгээний байгууллагад
тавигдах шаардлага**

3.1. Бүртгэгдэх үнэлгээний байгууллага дараах шаардлага хангасан байна:

3.1.1. Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт /цаашид “ММҮИ” гэх /-ээс зохион байгуулсан үнэт цаасны зах зээлийн талаарх төрөлжсөн сургалтад хамрагдаж үнэмлэх авсан 2-оос доошгүй орон тооны үнэлгээчинтэй байх;

3.1.2. үнэлгээчид нь үнэлгээний үйл ажиллагааг 3-аас доошгүй жил эрхэлсэн;

3.1.3. үнэлгээчид нь мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдал гаргаж байгаагүй, энэ талаар ММҮИ-ээс тодорхойлолт гаргуулсан;

3.1.4. хууль тогтоомжид заасан бусад.

**Дөрөв. Бүртгэгдэх хуулийн компанид
тавигдах шаардлага**

4.1 Бүртгэгдэх хуулийн компани нь дараах шаардлага хангасан байна:

4.1.1. хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх шалгалтад тэнцэж гэрчилгээ авсан 2 ба түүнээс дээш орон тооны ажилтантай байх;

4.1.2. орон тооны ажилтнууд нь эрх зүйн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг 3-аас доошгүй жил эрхэлсэн;

4.1.3. ажилтнууд нь ял шийтгүүлж байгаагүй /мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдал гаргаж байгаагүй, энэ талаар эрх бүхий байгууллагаас тодорхойлолт гаргуулсан/;

4.1.4. хууль тогтоомжид заасан бусад.

Тав. Бүртгүүлэх, сунгуулах этгээдийн бүрдүүлэх баримт бичиг

5.1 Энэхүү журмын шаардлагыг хангасан аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компани нь бүртгүүлэх, сунгуулах хүсэлтээ дор дурдсан баримт бичгийн хамт ирүүлнэ:

5.1.1 бүртгүүлэхийг хүссэн өргөдөл /журмын 1-р хавсралт маягт/;

5.1.2. компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний болон дүрмийн хуулбар, холбогдох тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;

5.1.3. орон тооны аудитор, орон тооны үнэлгээчид болон хуульчийн тухайн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл, эрхийн гэрчилгээ, нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар баталгаажуулсан хуулбар, мэргэжлийн байгууллагаас зохион байгуулсан төрөлжсөн сургалтад хамрагдсаныг гэрчлэх болон мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдсаныг нотлох баримт бичгийн хуулбар;

5.1.4. компанийн ажилтнууд нь мэргэжлийн болон ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй тухай тодорхойлолт;

5.1.5. аудит, үнэлгээний байгууллагын хувьд үнэт цаас гаргасан болон нийтэд санал болгон үнэт цаас гаргахаар танилцуулга бэлдэж байгаа компанид Хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан "Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам"-ын 2.2.1, 2.2.2-д заасны дагуу дүгнэлт гаргахын тулд хийгдэх аудит, үнэлгээний үйл ажиллагааны журам;

5.1.6. хуулийн компанийн хувьд Хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан "Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам"-ын 2.2.3-т заасны дагуу дүгнэлт гаргахад мөрдөх журам;

5.1.7. аудит, үнэлгээний байгууллага болон хуулийн компанийн үйл ажиллагааны талаарх түүхчилсэн дэлгэрэнгүй танилцуулга;

Зургаа. Аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компанийг бүртгэх, хугацааг сунгах, бүртгэлээс хасах

6.1. Хороо тухайн байгууллагаас ирүүлсэн баримт бичгийг хүлээн авсанаас хойш ажлын 20 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ.

6.2. Хороо аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компанийг шаардлага хангасан гэж үзвэл үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх этгээдээр 3 жилийн хугацаатайгаар бүртгэнэ.

6.3. Бүртгэлийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө хугацааг сунгуулах хүсэлтийг энэхүү журамд заасан шаардлагыг хангасан баримт бичгийн хамт Хороонд бичгээр ирүүлнэ.

6.4. Аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компанийн бүртгэлийн хугацаагаа сунгуулах тухай хүсэлтийг Хорооны Ажлын алба тухайн байгууллагын ажлын гүйцэтгэлийн дүн, чанар байдлыг харгалзан холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж Хороогоор шийдвэрлүүлнэ.

6.5. Хороо бүртгэх, бүртгэлийн хугацааг сунгахаас татгалзсан тохиолдолд энэ тухай үндэслэл бүхий мэдэгдлийг хүсэлт гаргасан этгээдэд албан ёсоор хүргүүлнэ.

6.6. Бүртгэгдсэн этгээд дор дурдсан зөрчил дутагдал гаргасан тохиолдолд Хороо бүртгэлээс хасна:

6.6.1. аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компани өөрөө хүсэлт гаргасан;

6.6.2 энэхүү журмын 2, 3, 4 дүгээр бүлэгт заасан шаардлагуудын аль нэгийг болон бүгдийг хангахгүй болсон;

6.6.3. бүртгүүлэхдээ хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

6.6.4. буруу дүгнэлт гаргасан, дагаж мөрдвөл зохих журам, дүрэм, зарчмыг зөрчсөн, үйлчлүүлэгчийн болон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан, түүнтэй адилтгах нөхцөл байдал үүсгэсэн;

6.6.5 Хороо ашиг сонирхолын зөрчил бүхий нөхцөл байдал бий болсон гэж үзсэн;

6.6.6. холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн нь тогтоогдсон.

6.7. Энэ журмын 6.6.1, 6.6.2-д зааснаас бусад үндэслэлээр бүртгэлээс хасагдсан этгээд бүртгэлээс хасагдсанаас хойш 5 жилийн хугацаанд Хороонд дахин бүртгүүлэхээр хандах эрхгүй байна.

6.8. Хороонд бүртгүүлэхээр шинээр хандсан болон бүртгэлтэй хуулийн этгээд энэ журмын 6.6.1, 6.6.2-д зааснаас бусад үндэслэлээр бүртгэлээс хасагдсан этгээдэд ажиллаж байсан аудитор, үнэлгээчин, хуульчийг авч ажиллуулахыг хориглоно.

6.9. Хорооны тусгай зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хариуцсан ажилтан үнэт цаас гаргагчид аудит, үнэлгээ, хууль, эрх зүйн дүгнэлт хийх этгээдийг бүртгэсэн, бүртгэлийн хугацааг сунгасан, бүртгэлээс хассан талаарх дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлж Хорооны

Эрсдэлийн үнэлгээ, судалгаа, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний газар, Үнэт цаасны газар, Эрх зүйн хэлтсүүдэд тухай бүр мэдэгдэж байна.

6.10. Аудит, үнэлгээ, хууль, эрх зүйн үйлчилгээ үзүүлэх этгээдүүдийг бүртгэсэн, бүртгэлийн хугацааг сунгасан, бүртгэлээс хассан тухай Хорооны шийдвэрийг Эрсдэлийн үнэлгээ, судалгаа, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний газар болон Үнэт цаасны газар, Эрх зүйн хэлтсүүд ажлын 10 хоногт багтаан үнэт цаас гаргагч, олон нийтэд цахим сүлжээгээр мэдээлнэ.

Долоо. Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх этгээдийн төрөлжсөн сургалт

7.1 Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх этгээд нь “Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалт”, “Компанийн засаглал”, “Үнэт цаасны зах зээлтэй холбоотой үнэлгээ, аудитын онцлог” зэрэг чиглэлээр төрөлжсөн сургалтад хамрагдаж, зохих шалгалтыг өгсөн байна.

7.2 Аудитор, үнэлгээчдийн хувьд сургалт, шалгалтыг эдгээр мэргэжилтнүүд харьяалагддаг мэргэжлийн байгууллага /ММНБИ, ММҮИ/-ууд зохион байгуулна.

Найм. Аудит, үнэлгээ, эрх зүйн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх

8.1. Үнэт цаасны зах зээл дээр үйлчилгээ үзүүлэхээр бүртгэгдсэн аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компани нь үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, олон улсын стандарт, эрх бүхий байгууллагаас батлан гаргасан арга, аргачлал, журмыг мөрдөнө.

8.2. Аудит, үнэлгээний байгууллагаас үнэт цаас гаргах танилцуулга, үнэт цаас гаргагчийн санхүүгийн болон бусад үйл ажиллагааны талаар гаргасан тайлан дүгнэлтийг Хорооны Эрсдэлийн үнэлгээ, судалгаа, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний газар, эрх зүйн дүгнэлтийг Эрх зүйн хэлтэс хянаж хүлээн зөвшөөрөх эсэх талаар үндэслэл бүхий санал, дүгнэлтээ Үнэт цаасны газарт хүргүүлнэ.

Ес. Хариуцлага

9.1. Хороо энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн этгээдийг холбогдох мэргэжлийн байгууллагуудад нь мэдэгдэх, үнэт цаасны зах зээл дээр үйлчилгээ үзүүлэх этгээдийг бүртгэлээс хасах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан олон нийтэд анхааруулах арга хэмжээ авна.

9.2. Бүртгэлтэй этгээдийн аливаа хууль зөрчсөн үйл ажиллагаа нь гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл Хороо хууль хяналтын байгууллагад хандаж шалгуулна.

---ooOoo---

БҮРТГҮҮЛЭХИЙГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Огноо :
 Хаана: Санхүүгийн зохицуулах хороо,
 Засгийн газрын IV байр
 Бага тойруу -3
 Улаанбаатар -15160
 Монгол улс.

Хэнээс:

(өргөдөл гаргагчийн овог, нэр, эрхэлж буй албан тушаал, хаяг, утас, факс, электрон шуудангийн хаяг)

.....
 /Аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компанийн нэр ХК, ХХК, товчоо/

Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн:

№	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар /Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар/	Хаяг	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувь (мянган төгрөгөөр)

Компанийн гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтан нь /гүйцэтгэх захирал, нэгжгийн удирдлага, дотоод хяналтын ажилтнууд/ дараах хүмүүс болно:

№	Овог, нэр	Одоогийн эрхэлж байгаа ажил	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар	Мэргэжлийн байгууллагад эрхлэх албан тушаал

Аудит, үнэлгээ, эрх зүйн үйлчилгээ үзүүлэх ажилтнууд нь дараах хүмүүс болно:

№	Овог, нэр	Регистрийн болон иргэний үнэмлэхийн дугаар	Гэрийн хаяг	Тухайн ажил үйлчилгээг эрхэлсэн хугацаа	Албан тушаал	Тухайн ажил үйлчилгээг эрхлэх эрхийн үнэмлэхийн дугаар

Бүртгүүлэхээр хүргүүлсэн баримтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны ... дугаар сарын ...-ний өдрийн .. дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компанийг бүртгэх тухай журам”-ын шаардлагад нийцүүлэн үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн бичиг баримтад аливаа худал ташаа зүйл байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, холбогдох бичиг баримтыг хянан шалгаж, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой дүгнэлт гаргах этгээдээр бүртгэн авна уу.

Бид үйл ажиллагаандаа Иргэний хууль, Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Аудитийн тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай болон бусад холбогдох хууль тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллах ба Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагуудыг бүрэн биелүүлж байх болно.

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:

/...../	/...../
/гарын үсэг/	/овог, нэр/
/...../	/ албан тушаал /

/тамга тэмдэг/